

Тэмбүү, өвчтөнд өгөх мэдээлэл

Би яагаад энэ мэдээллийг авсан бэ?

Та тэмбүү өвчний халдвар авсан эсвэл халдвартай байх магадлалтай. Эндээс та тэмбүү, үүнийг хэрхэн эмчилдэг, мөн та юу хийх хэрэгтэй тухай мэдээлэл авна.

Тэмбүү гэж юу вэ?

Тэмбүү бол бактериар үүсгэгддэг өвчин юм. Тэмбүүн бактери нь бэлэг эрхтэний салст бүрхэвч эсвэл арьсанд, шулуун гэдэсний амсар эсвэл амны орчимд халдварлаж болно. Бактери цусанд бас байж болно. Тэмбүү хүний биед шинж тэмдэггүйгээр олон жил оршиж болно.

Би тэмбүүтэй болсноо хэрхэн мэдэх вэ?

Халдвар авсан хүмүүсийн ихэнх нь шинж тэмдэггүй байдаг.

Зарим хүний бэлэг эрхтэн, шулуун гэдэсний амсар эсвэл ам дотор/орчимд шарх үүсч болно. Шарх ихэвчлэн хэдэн долоо хоногийн дараа арилна. Зарим хүний бие болон голдуугарын алга, хөлийн уланд тууралт үүсдэг.

Тэмбүү аюултай юу?

Эмчлээгүй тэмбүү хэд хэдэн эрхтэнд хүнд гэмтэл үүсгэж болно.

Тэмбүү хэрхэн халдварладаг вэ?

Тэмбүү нь хамгаалалтгүй үтрээ, шулуун гэдэс эсвэл аман сексийн үед дамждаг. Жирэмсний үед эх хүүхэддээ халдварлах эрсдэлтэй. Бүх жирэмсэн эмэгтэйчүүдэд жирэмсний эхэн үед тэмбүүгийн шинжилгээ хийлгэхийг санал болгодог. Ямар ч шинж тэмдэггүй хүн ч бусдад тэмбүү тараах магадлалтай. Халдвар авснаас хойш нэг жилийн дотор эмчлэгдээгүй тэмбүү бусдад бэлгийн замаар дамжина. Харин цусаар эсвэл жирэмсний үед хүүхэдэд дамжих нь халдвар авснаас хойш нэг жилээс илүү хугацааны дараа тохиолдоно.

Тэмбүүд дархлаатай болдоггүй тул хэд хэдэн удаа ч тэмбүүгээр халдварлаж болно.

Тэмбүү хувцас, алчуур, жорлонгоор дамжин халдварлахгүй.

Тэмбүүг хэрхэн эмчлэх вэ, би хэр удаан бусдад халдварлах магадлалтай вэ?

Тэмбүүг антибиотикоор эмчилдэг (тариа эсвэл шахмал эм). Эмчилгээг зохих ёсоор хийлгэж, өгсөн зөвлөмжийг дагаж мөрдвөл халдвар арилна. Эмчилгээ болон эмчтэй хийх уулзалт үнэ төлбөргүй. Эмч таныг хэр удаан бусдад халдвартай байхыг хэлнэ, тэр нь ихэвчлэн сүүлийн антибиотик тарилга хийснээс хойш нэг долоо хоног хүртэлх хугацаа юм.

Танд давтан цаг өгсөн бол та хүлээн авах дээр буцаж ирэх ёстой. Халдвар арилсан эсэхийг шалгахын тулд ихэвчлэн хэдэн сарын дараа шинэ цусны шинжилгээ авна.

Шинжилгээ авах үед тэмбүүтэй болох нь харагдах уу?

Тодорхой хугацаа өнгөрсний дараа тэмбүүгийн цусны шинжилгээ өгөх үед өмнө нь таныг тэмбүүтэй байсныг илтгэх хариу гарах магадлалтай. Ийм тохиолдолд лаборатори таныг дахин халдвар авсан эсэхийг шалгахын тулд нэмэлт шинжилгээ авна.

Бусдад халдварлахгүйн тулд би юуг анхаарах ёстой вэ?

Тэмбүү нь Халдвараас хамгаалах хуулийн дагуу нийтэд аюултай өвчин юм. Тэмбүүтэй эсвэл тэмбүүтэй байх магадлалтай та Дагах дүрэм гэгддэг тодорхой дүрмийг даган мөрдөх ёстой.

Дагах дүрэм

- Та бэлгийн хавьталд орохдоо тэмбүүтэй/эсвэл тийм байх магадлалтай тухайгаа хэлэх ёстой.
- Эмчилгээ дуусч, шинжилгээ өгөхөөс өмнө та бэлгийн хавьталд орох бол хамгаалалт хэрэглэх ёстой.
- Танд хүлээн авах дээр давтан цаг өгсөн бол та очих ёстой.

Хэрэв та дагах дүрмийг буруу гэж үзэж буй бол өөрийн бүс нутгийн халдвар хамгааллын эмчтэй холбоо барьж болно.

Та тэмбүүн халдвартай бол өөр хүнд халдварлах эрсдлээс зайлсхийх ёстой. Эмч таныг тэмбүүгүй гэж хэлэхээс өмнө та бэлгийн хавьталт эсвэл өөр төрлийн секс хийхгүй байх нь хамгийн найдвартай арга юм. Эмч сүүлийн тариа тарьснаас хойш нэг долоо хоногийн дараа ингэж хэлэх магадлалтай. Хэрэв үүнээс өмнө бэлгийн хавьталд орвол та нөгөө хүндээ тэмбүүтэй гэдгээ хэлж, хамгаалалт (бэлгэвч) хэрэглэх ёстой.

Халдвар мөрдөлт

Тэмбүүтэй хүмүүсийг хайж олох нь тэдний эмчилгээ хийлгэж, гэмтэх эрсдлээ (дээрхийг харна уу) бууруулахад нь чухал ба, нөгөө талаар халдвар илүү олон хүнд тархахгүй байхад ач холбогдолтой.

Халдвараас хамгаалах хуулийн дагуу та халдвар мөрдөлтийн ажилд оролцох ёстой. Энэ нь та хэнтэй бэлгийн хавьталд орсон тухайгаа халдвар мөрдөгчид хэлэх ёстой гэсэн үг юм. Заримдаа бүр нэг жилийн өмнө хавьтсан хүний тухай мэдээлэл өгөх шаардлагатай.

Таны хэлж байгаа зүйл нууц бөгөөд таны хэлсэн хүмүүс таныг хэн бэ гэдгийг мэдэхгүй. Тэд зөвхөн шинжилгээнд хамрагдах ёстой гэдгээ л мэдэж авна. Энэ мэдээлэл таны өвчний түүхэд орохгүй, халдвар мөрдөлтийн тусгай баримт бичигт орно.

Нэмэлт мэдээлэл

Тэмбүү өвчний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 1177, Youmo (өөр хэл дээр мэдээлэл авах хүсэлтэй 13-20 насны танд) болон UMO дээрээс (өсвөр насны хүүхэд, залуучуудын цахим эмнэлэг) авах боломжтой.

www.1177.se



www.youmo.se



www.umo.se



Халдвараас хамгаалах хуудсын тухай

Халдвараас хамгаалах хуудсыг Халдвар хамгааллын эмч нарын нийгэмлэг боловсруулсан бөгөөд үндэсний хэмжээнд хамаатай.